

2021 оны 2-р сар

Оюу Толгойн уурхай, Монгол улс. Түүхий ХЭЛЦЭЛ

МХХТ (Make ICT Fair consortium-Мэдээлэл, харилцаа холбооны технологийг шударгажуулах консорциум - цаашид МХХТ гэх)-ийн **металл олборлолтын салбар дахь оноосон судалгаа**

Зохиогч: Maya Kalcheva

Найруулсан: Fidanka Bacheva-McGrath Emily Gray

Дизайн: Milan Trivic

Талархал: Дүгэрсүрэнгийн Сүхгэрэл, Paul Robinson, Caitlin Daniel and Aleksandra Antonowicz-Cyglicka

Оюу Толгойн хяналт ТББ (**OT Watch**) нь Монгол улс дахь иргэний нийгмийн байгууллага юм. Нүүдэлчин малчдад байгаль орчны болон хүний эрхийн олон улсын хэм хэмжээ, стандартыг сурталчлах, хэрэглэх сургалтанд хамруулж тэдгээрийг энэ тал дээр чадавхижуулах дэмжлэг үзүүлдэг болно. OT Watch нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Олон Улсын Санхүүгийн Корпораци зэрэг Дэлхийн банкны группийн банкуудаас Монголд уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн салбарт санхүүжилт хийж хэрэгжүүлж буй төслүүдийн үр дагаварт өртөж нийгэмлэгүүдтэй хамтран ажилладаг.

CEE Bankwatch Network нь Төв ба Зүүн Европын байгаль орчин, хүний эрхийг хамгаалах анхан шатны иргэний нийгэмлэгийн байгууллагуудын хамгийн том сүлжээ юм. Дэлхий даяар зуу зуун тэрбум доллараар хөрөнгө оруулалт хийдэг төрийн өмчлөлтэй санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьдаг. CEE Bankwatch Network нь орон нутгийн иргэд болон бусад ТББ-уудтай хамтарч эдгээр хөрөнгө оруулагчдын хязгааргүй нөлөөг илчилж, тэдний хяналтгүй хүчийг тэнцвэржүүлэх зорилготой ажилладаг юм.

МХХТ болон CEE Bankwatch Network-ийн уул уурхайтай холбоотой ажлын талаар

CEE Bankwatch Network нь Европ болон өөр бүс нутагт уул уурхайн төслүүдэд олон жилийн турш хяналт тавьж ирсэн. CEE Bankwatch нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн үйлдвэрлэл, хангамжийн сүлжээний бүх шатанд ашигт малтмалын хангамжийг шинэчлэх, салбарын ажилчид ба үйл ажиллагаанд нь өртөж буй хүмүүсийн амьдралыг сайжруулах зорилготой Мэдээлэл, харилцаа холбооны технологийг шударгажуулах консорциум (Make ICT Fair consortium -цаашид МХХТ гэх) –тай хамтарч ажилладаг. Уул уурхайн хүн амын ахуй амжиргаа, хүрээлэн орчинд үзүүлэх нөлөөллийг хянаж буй нийгмийн бүлэглэлүүд болон уурхай, хайлуулах үйлдвэрлэлийн үр дагаварт нэрвэгдэж буй нутгийн иргэдтэй бидний урт хугацаат хамтын ажиллагаа нь уул уурхайн олон сөрөг нөлөөллийг зүй зохист хяналтад авбал зохино гэсэн бидний итгэл үнэмшлийг улам бататгаж байдаг.

Үндсэн агуулга

Оюу Толгойн уурхай нь Монголын Говийн өмнөт хэсэгт байрлах дэлхийн хамгийн том алт, зэсийн ордуудын нэг юм. 2001 онд анх байгуулагдаж, 2010 оны арванхоёрдугаар сард ашиглалтад орсон уг уурхай нь 12 тэрбум орчим ам.долларын хөрөнгө шаардах тооцоотой Монгол дахь хамгийн том хөрөнгө оруулалтын төсөл юм¹. Оюу Толгой ХХК нь уг төслийг хэрэгжүүлэх зорилгоор 2009 онд байгуулагдсан бөгөөд түүнийг Монголын төрийн өмчит Эрдэнэс Оюу Толгой ХХК (ОТ) (34%) ба Рио Тинтогийн охин компани болох Turquoise Hill Resources (TRQ) (66%) тус тус хамтран эзэмшдэг юм. Уурхайн ил олборлолт 2010 оны сүүлчээр эхэлсэн ба анхны хөрөнгө оруулалт нь 6 тэрбум ам.доллар гэдэг. Үйлдвэрлэлийн анхны экспортын борлуулалт 2013 онд гарчээ. Далд уурхайн 2-р үе шатны бүтээн байгуулалтын төсөл нь 2016 оноос албан ёсоор эхэлж одоо үргэлжилж байна. Далд уурхайн тогтвортой үйлдвэрлэлийг 2022 оны 10-р сараас 2023 оны 6-р сарын хооронд² эхлүүлэхээр төлөвлөж байгаа байна. 2015 оны 12-р сард төслийн санхүүжилтэд олон улсын арилжааны болон хөгжлийн банкуудаас нийт 4.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт авахаар баталгаажуулсан. Анхдагч зээлдүүлэгчид нь Дэлхийн Банкны группд багтдаг Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) ба Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ) юм: синдикат (арилжааны банкуудтай хамтарсан) зээлийг оролцуулаад нийт 1.4 тэрбум гаруй ам.долларын зээлийг тэд баталсан болно.^{3 4} Эдгээр хоёр банк нь уурхайн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудалд хяналт тавьж ажиллах үүрэг хүлээдэг гэдэг. Монголын уурхайн тэргүүлэх төслийн хувьд Оюу Толгойг дэлхийн жишигт нийцсэн, тогтвортой, аюулгүй, эрчим хүчний хэмнэлттэй уул уурхайн төсөл гэх байдлаар сурталчилдаг болно. Ялангуяа, ОУСК зэрэг хөрөнгө оруулагчид нь энэхүү төсөл нь Монгол Улсын Засгийн газарт төлсөн татварын орлогоор, шинээр бий болгосон ажлын байраар, их дээд сургууль, мэргэжлийн сургалтанд оруулсан хөрөнгө оруулалтаар, орон нутагт оруулж буй зардлаар зэрэг Монголын ДНБ-ийг нэмэгдүүлэх эдийн засгийн үр өгөөжөө өгөх болно гэж сурталчилдаг.^{5 6} Бүр цаашилбал, уурхайд Гүний хоолойн

¹International Finance Corporation, IFC Support for Oyu Tolgoi, 05.02.2021. [1-Economic+Benefits.pdf \(ifc.org\)](#)

² Oyu Tolgoi, [Oyu Tolgoi announces Q2 2020 performance results \(ot.mn\)](#) , 17.08.2020.

³ International Finance Corporation, [IFC and MIGA to Provide More Than \\$2 Billion for Oyu Tolgoi, Engine of Mongolian Jobs and Growth](#), 15.12.2015.

⁴ European Bank for Reconstruction and Development, Oyu Tolgoi, 05.02.2021. [Oyu Tolgoi \(ebrd.com\)](#)

⁵ Rio Tinto, Oyu Tolgoi, 05.02.2021. [Oyu Tolgoi \(riotinto.com\)](#)

⁶ International Finance Corporation, IFC Support for Oyu Tolgoi. [1-Economic+Benefits.pdf \(ifc.org\)](#)

усны давхаргын 20 хувиас бага хэмжээг ашигладаг гэдгээр Рио Тинто нь ус хамгаалагч гэх байдлаар өргөмжлөгддөг юм. Мөн өнөө Turquoise Hill Resources нь 2014 оноос хойш жил бүр ашигласан усныхаа 84 гаруй хувийг тогтмол цэвэршүүлж ирсэн гэж мэдэгддэг.⁷ Гэвч эдгээр мэдэгдлүүдийн найдвартай эсэх нь маргаантай асуудал шиг болж байна, учир нь Монгол Улсын ДНБ 2011 онд 17.3% -иар огцом өссөнийг ажиглаж байсан бол 2016⁸ онд 1.1% болтол унаж, 2017⁹ онд Олон Улсын Валютын сангийн тусламжийн багцыг хүлээн авах шаардлагатай болов. Цаашилбал, ОТ нь усны хэрэглээ, цэвэршүүлэлтийн хувь хэмжээтэй холбоотой дэлгэрэнгүй тайлан, мэдээллийг иргэний нийгмийн байгууллагуудад өгөхөөс байнга татгалздаг тул төслийн хэрэгжүүлэгчийн үнэнч худалч нь эргэлзээтэй ба хөндлөнгийн ажиглагчдад ийнхүү мэдэгдэл, амлалтуудыг нь гэрчлэхэд бэрхшээлтэй¹⁰ байдаг байна. Нэмээд, Монгол Улсын Засгийн газраас Оюутолгой ба Өмнөговь аймгийн бүс нутгийг Орхон голоос 740 км урт Орхон-Говь усан хоолойгоор хангах төслийг эхлүүлэхээр шийдвэрлэсэн нь уурхайн ус ашиглалтын тогтвортой байдал¹¹ нь эргэлзээ төрүүлж байна.

Сүүлийн үеийн үйл явдлын өрнөлт ба асуултууд

ОТ уурхайг байгуулахаар 2009 оны 10-р сард Монгол Улсын Засгийн газар ба Рио Тинтогийн хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ нь авлигын дуулиан, татварын маргаан, санхүүгийн бэрхшээл, үйлдвэрлэлийн саатал зэргээр төрөл төрлийн сааталтай байв.

1. Далд уурхайн олборлолт 2021 онд эхлэхээр төлөвлөгдөж байсан. Гэвч Рио Тинто нь үйлдвэлдэлийн эхлэлийг 21-29 сараар хойшлуулах, мөн төслийн өртөг 1.3-1.8 тэрбум ам.доллараар гарсан 5.3 тэрбум дээр нэмэгдэх төлөвтэй байгаа тухай шинэ ТЭЗҮ-г 2020 оны 7-р сард зарлав. Мөн түүнчлэн, COVID-19 хямралын улмаас нэмэлт саатал, хөрөнгийн өсөлт гарч болзошгүй гэж компани мэдэгдэв¹². Эл шалтгаанаар Рио Тинто ба түүний охин компани TRQ нь өрийн эргэн төлөлтийг дахин хэлэлцэж, товлосон зээлдүүлэгчдээс 500 сая хүртэл

⁷ Turquoise Hill, Sustainability: Water, 05.02.2021. [Water | Turquoise Hill Resources](#)

⁸ The World Bank – [GDP growth \(annual %\) - Mongolia | Data \(worldbank.org\)](#) 05.02.2021.

⁹ Terrence Edwards, [Mongolia agrees \\$5.5 billion economic bailout plan with IMF, others | Reuters](#), 19.02.2017.

¹⁰ Хариуцлагын зөвлөлөөс Кэйтлин Даниелын олсон 10 зүйл.

¹¹ Өмнөговь аймгийн 2018 оны тайланд хийсэн суурь судалгаа: 2008-2018 онд Өмнөговь аймгийн байгаль орчны үзүүлэлтүүдийн өөрчлөлт.

¹² Rio Tinto, [Oyu Tolgoi mine design confirms project schedule and cost ranges and update to Ore Reserves and Mineral Resources \(riotinto.com\)](#), 03.07.2020.

ам.долларын хөрөнгө нэмж босгохыг эрмэлзэж байгаа аж¹³. 2020 оны 11-р сарын 4-ний өдөр TRQ нь Оюутолгой төсөлд нэмэлт санхүүжилт олох үйл ажиллагаанд өөрийн гүйцэтгэх үүргийг тодруулах арбитрын ажиллагааг эхлүүлж байгаагаа мэдэгдэв¹⁴. Мөн 2020 оны 10-р сарын 15-ны байдлаар Рио Тинто, TRQ аль аль нь уурхайн найдвартай инженерийн төлөвлөлт, бүтээн байгуулалтын асуудлаар мэдээлэл нуусан улмаас өртөг зардал нэмэгдэж, ашиглалтын хугацаа хойшлогдож буй тухайд хувьцаа эзэмшигчдийн нэхэмжлэлээр хариуцагчаар оролцохоор байгааг тэмдэглэх нь зүйтэй¹⁵.

2. Төсөл нь олон удаагийн шинэчилсэн яриа хэлэлцээнд хамрагдаж байна. Хамгийн сүүлчийнх нь төсөлд хүлээгдэж байснаас илүү их өр хуримтлуулсан, олборлолт хойшлогдох тухай шинээр гарсан мэдээллийг зарласнаас хойш Монголын төрөөс томилогдсон ажлын хэсэг талуудын хөрөнгө оруулалтын гэрээний хамгийн сүүлийн хувилбар болох 2015 оны Оюу Толгойн далд уурхайн хөгжил, санхүүжилтийн төлөвлөгөө (Дубайн гэрээ)-нд үнэлгээ хийв. 2019 оны 5-р сард ажлын хэсгийн зүгээс ОТ-н төслийн Хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулж, Дубайн гэрээг "цуцлах"-ыг зөвлөв. Энэхүү гэрээ нь "харилцан ашигтай" биш байтугай хууль эрх зүйн хувьд хүчин төгөлдөр бусд тооцогдсон тул өртөг зардлын хэтрэлт, удаашрал цаашид хуримтлагдаад байх төлөвтэй байгаа болно. Мөн түүнчлэн, уг төслөөс Монгол улс хэзээнээс ногдол ашиг авч эхлэх тухай асуудлыг тодруулахыг ажлын хэсгийнхэн түлхүү шаардав¹⁶. Магад үүнтэй холбогдуулан 2019 оны 11-р сард Дархан Монгол Ногоон Нэгдэл төрийн бус байгууллага Захиргааны хэргийн шүүхэд МУ-ын ЗГ-ыг Рио Тинтотой Дубайн гэрээ байгуулахдаа зохих хууль журмыг зөрчсөн гэж буруутган нэхэмжлэл гаргав¹⁷. Нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн гэж мэдээлсэн; Гэвч 2019 оны 12-р сард УИХ-аас тогтоол гаргаж, Рио Тинто нь Хөрөнгө оруулалтын гэрээг Монголын засгийн газартай ойрын хугацаанд дахин хэлэлцэхээр байна гэж мэдэгдэв¹⁸.

¹³ Rio Tinto, [Rio Tinto and Turquoise Hill Resources agree funding plan for Oyu Tolgoi](#), 10.09.2020.

¹⁴ Turquoise Hill Resources Ltd., [Turquoise Hill to commence arbitration to seek clarity with respect to financing \(prnewswire.com\)](#), 04.11. 2020.

¹⁵[Notice of Lead Plaintiff Deadline for Shareholders in the Turquoise Hill Resources Ltd. Class Action Lawsuit | Business Wire](#), 16.10. 2020.

¹⁶ Myagmardorj Buyanjargal, [Oyu Tolgoi's brewing tax row \(theubposts.com\)](#) , 15.11. 2019.

¹⁷ Dulguun Bayarsaikhan, [Has the Oyu Tolgoi's Dubai deal been voided? \(theubposts.com\)](#), 19.11. 2019.

¹⁸ [Rio Tinto Notes Mongolian Parliament Resolution on Oyu Tolgoi | Business Wire](#), 11.12. 2019

3. Рио Тинто нь ОТ ХХК-ийн татвартай холбоотой хэд хэдэн маргааныг - үүнд 2014¹⁹ ба 2017²⁰ онуудых орно - Монголын төртэй үүсгээд байгаа болно. 2020 оны 2-р сард Рио Тинто нь Оюу Толгой ХХК-аас 2013-2015 оны хооронд төлсөн 155 сая ам.долларын татварын асуудлаар олон улсын арбитрын нэхэмжлэлийг Олон улсын худалдааны эрх зүйн комисст гаргасан гэсэн мэдээлэл байна. ОТ нь эдгээр татварыг аль хэдийн төлсөн гэж маргаж байгаа байна²¹. Энэ маргаан үргэлжилсээр байгаа бололтой²². Рио Тинтог өөрийг шалгаагүй байгаа боловч уул уурхайн төсөлд оролцож байсан хоёр ч монголын улс төрчийг хээл хахуулийн хэрэгт сэжиглэж байна. Рио Тинтотой 2009 онд гэрээнд гарын үсэг зурахаас өмнөхөн тухайн үеийн Сангийн сайд асан Сангажавын Баярцогт уул уурхайн салбарын бизнес эрхлэгч Борхүүгийн Дэлгэрсайханаас Швейцарийн банк дахь дансандаа 8.2 сая евро авсан тухай мэдээлж байсан. Харин Дэлгэрсайхан нь уг мөнгийг "Хятадын нууцлаг хөрөнгө оруулагч" -аас авсан гэсэн мэдээлэл байна. Энэхүү мөрдөн байцаалтын явцад Баярцогтыг 2018 ба 2019 онуудад хоёр удаа баривчилсан боловч эцэст нь тухайн хоёр тохиолдолд буруутгалгүйгээр суллагджээ.

Монголын Авлигатай Тэмцэх газраас уг асуудлаар мөрдөн байцаалт явуулж эхэлсэн боловч Баярцогт, Дэлгэрсайхан нарыг хуйвалдаанд холбогдсон эсэх нь тодорхойгүй байна. Швейцарийн Ерөнхий прокурорын газар (SOAG) 2016 онд мөн дээрх хоёр этгээдийг шалгаж эхэлсэн ба дансан дахь 1.85 сая ам.долларыг царцаажээ. 2020 оны 4-р сард Дэлгэрсайханд бичиг баримт хуурамчаар үйлдсэн хэргээр "ял оноох захирамж" гаргасан, харин тэрээр давж заалдах тухайгаа мэдэгдсэн. Мэдээ үзвэл, 2020 оны сонгуульд²³ хоёулаа УИХ-д нэр дэвшиж, Дэлгэрсайхан нь сонгогдсон байдаг. С.Баярцогтыг төрийн албанд байхдаа эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан гэх яллын дүгнэлтээр 2020 оны 7-р сард Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 10 жилийн хорих ял оноосон

¹⁹ [Rio Tinto Settles Tax Dispute with Mongolia; Oyu Tolgoi Mine Back On Track | Supply Chain & Operations | Mining Global](#), 15.09.2020

²⁰ Buyanjargal, [Oyu Tolgoi's brewing tax row \(theubposts.com\)](#)

²¹ [Rio Tinto seeks international arbitration on tax dispute with Mongolia | Reuters](#), 20.02. 2020.

²² 2018 оны эцсээр Рио Тинтог Люксембург, Нидерландын шуудангийн хайрцаг төдий оффшор компаниудыг ашиглан Канад ба Монгол Улсын татвараас зайлсхийн 700 сая ам.долларын алдагдалд оруулсан гэж Нидерландын СОМО ТББ буруутгасан нь анхаарал татаж байв. Гэвч Рио Тинтогийн энэ татварын практик нь хууль бус, гэрээг зүй бусаар ашигласан гэх нь нотлогдоогүй гэж үзсэн байдаг. [Rio Tinto's tax schemes lead to nearly \\$700 million tax revenue losses for Canada and Mongolia \(somo.nl\)](#), 31.01.2018 харгах

²³ Karine Pfenniger, [Candidates in Mongolian elections face Swiss charges - SWI swissinfo.ch](#), 25.06. 2020.

байна²⁴. 2020 оны 12-р сард Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хуралдааны шийдвэрээр хорих ялыг 4.8 жил болгон бууруулав.

Байгаль орчин, нийгмийн асуудалд холбогдох үйл явдлын өрнөлт

Төслийг ОУСК ба ЕСБХБ-аас санхүүжүүлсэн бол ОУСК-ийн Гүйцэтгэлийн Стандартууд болон ЕСБХБ-ны Байгаль орчны талаар баримтлах бодлогын шаардлагыг дагаж мөрдөх ёстой байдаг.^{25 26} ЕСБХБ-аас "эрсдэл" гэж хүлээн зөвшөөрч, одоогоор идэвхтэй хяналтанд авдаг гол гол асуудлуудад ус, биологийн нөөцөд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, мөн тухайн бүс нутгийн оршин суугчдын материаллаг нөхцөл байдал буурсан зэрэг асуудлууд багтдаг.

Банкнаас санхүүжиж буй төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаар тавигдах шаардлагын хамгийн сүүлийн шинэчлэлийг 2019 оны 5-р сард хийсэн.²⁷ Нутгийн усны нөөц, биологийн олон янз байдал нөлөөнд өртөөгүй, эдийн засгийн хувьд нүүлгэн шилжүүлэгдсэн малчин өрхүүдийн 88 хувийн эдийн засгийн нөхцөл байдал 2011 онтой харьцуулахад сайжирсан гэсэн эерэг гэх ерөнхий үнэлгээ хийсэн байна. Гэвч шинэчлэгдсэн шаардлагад буурч буй нүүдэлчдийн соёлыг дэмжихийн ач холбогдлыг онцолж, бэлчээрийн даац хэтрэх, усны хүртээмжийг ЕСБХБ цаашид анхааралтай ажиглахыг гол асуудал болгоно гэж заасан байдаг.

Ийнхүү тогтвортой хөгжлийн хүрээн дэх шаардлагаар өртсөн малчдын амьжиргаанд үзүүлэх нөлөө, усны хомсдол, бэлчээрийн талбайн хуваарилалт, нүүрсний эрчим хүчийг ашиглах төлөвлөгөө зэрэг нийгмийн болон байгаль орчны гол төлөв даамжирсан асуудлуудтай ОТ-н төсөл нь тулгарсаар байгаа байна.

Малчдын гомдол

Энэхүү төсөл нь Өмнөговийн Ханбогд сумын малчдыг 50,000 гаруй акр буюу 202,3 км² бэлчээрийг орхиход хүргэсэн ба 'газар усаа ашиглах уламжлалт соёл, нүүдэлчин

²⁴ [Шүүх: С.Баяр, С.Баярцогтын нарыг ялыг 2-5 жилээр бууруулав | News.MN](#), 12.05. 2020.

²⁵ International Finance Corporation, Oyu Tolgoi LLC – Environmental and Social Review Summary, 23.01. 2015-оос хойш шинэчлэгдээгүй. [Disclosure - Oyu Tolgoi LLC \(ifc.org\)](#)

²⁶ European Bank for Reconstruction and Development, Project summary document: Oyu Tolgoi, 05.09. 2012-д нийтэлсэн. [Oyu Tolgoi \(ebrd.com\)](#)

²⁷ European Bank for Reconstruction and Development, Project summary document: Oyu Tolgoi. [Oyu Tolgoi \(ebrd.com\)](#)

амьдралынх нь хэв маягт заналхийлж байна гэжээ'.²⁸ 2004 онд нийтдээ 11 малчин өрхийг биеэр нь нүүлгэн шилжүүлсэн мөн 89 өрхийн "эдийн засгийн хувьд суурийг нь хөдөлгөсөн" гэж хүлээн зөвшөөрөгдөж нөхөн олговрын багц авах болзол хангасан байна.²⁹ Мөн, анхнаасаа ус ховордсон гэх газарт олдоц нөөцөөс уурхайн усны хэрэглээ давах төлөвтэй байсан нь асуудалд няхуур хандах асуудал байв. 2012, 2013 онуудад нөлөөлөлд өртсөн малчид OTWatch ба Говийн Хөрс ТББ-уудын тусламжтайгаар ОУСК-ийн Хууль журмыг дагаж мөрдөх зөвлөх/Омбудсман (CAO)-д хоёр нэхэмжлэл гаргасан нь эхлээд Банкны Мэдээллийн Төв, дараа нь Хариуцлагын зөвлөлөөс дэмжигдсэн гэх мэдээ байна. Эхний гомдол нь 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, мөрөөр 2011 онд хийгдсэн нөхөн олговрын хэрэгжилт хангалтгүй байсантай холбоотой байсан бол хоёр дахь нь усны болон бэлчээрийн хүртээмжийг нэмэгдүүлэн зохион байгуулахыг шаардсан байв.^{30 31}

2004 оны 'нүүлгэн шилжүүлэх үйл явц хангалтгүй байсныг' ОТ хүлээн зөвшөөрч дараа гарах гомдлуудыг шийдвэрлэж байх зорилгоор 2015 онд малчид, Ханбогд сумын нутгийн захиргаа, ОТ ХХК -ийн тал бүрээс тэгш төлөөлөл бүхий Гурван талт зөвлөл (ГТЗ) байгуулагдав. Эдгээр гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 2016 онд Олон талт мэргэжлийн баг (Multi-Disciplinary Team - MDT) болон Хараат бус шинжээчдийн бүлэг (Independent Experts' Panel - IEP) дээрх нөлөөллийг үнэлэх судалгаа хийж 2017 оны 1-р сард нийтлэв.³² Энэхүү судалгаанд ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартыг зөрчсөн гэхээс гадна ОТ-ийн олборлолтын үйл ажиллагаа нь усны нөөц ба бэлчээрийн хуваарилалтад сөргөөр нөлөөлсөн талаар хэд хэдэн анхаарал татсан асуудлууд туссан байгаа (доор дэлгэрэнгүй танилцна уу).

2017 оны 5-р сард ГТЗ-ийн талууд Өргөдөл гомдлыг шийдвэрлэх гэрээнд гарын үсэг зурав. 2019 оны 3-р сард CAO нь ГТЗ-өөс дэмжснээр хэргийг албан ёсоор хаасан; гэвч тухайн үед шийдвэрлэвэл зохих үүргийн зөвхөн 29 хувь нь биелсэн ба ахиц дэвшил нь эргэлзээтэй гэж Хариуцлагын зөвлөл үзжээ.

²⁸ Compliance Advisor Ombudsman, CAO Dispute Resolution Conclusion Report - Oyu Tolgoi 01 & 02/Southern Gobi, [CAOMongolia Conclusion Rpt 2020-05-ENG.pdf](https://cao-ombudsman.org/CAOMongolia_Conclusion_Rpt_2020-05-ENG.pdf) (cao-ombudsman.org)

²⁹ OT Watch to Megan Taylor, Vice-President, Compliance Advisor Ombudsman, 12.10.2021, [OyuTolgoiCAOComplaint_Oct122012_Redacted.pdf](https://cao-ombudsman.org/OyuTolgoiCAOComplaint_Oct122012_Redacted.pdf) (cao-ombudsman.org)

³⁰ 30 Accountability Counsel, Mongolia: South Gobi mining - overview, 05.02.2021-нд тавьсан. [Page not found \(accountabilitycounsel.org\)](https://accountabilitycounsel.org) !!!!

³¹ 31 Accountability Counsel, Mongolia: South Gobi mining – case story, 05.02.2021-нд тавьсан. [Page not found \(accountabilitycounsel.org\)](https://accountabilitycounsel.org) !!!!

³² JSL Consulting Ltd., MultiDisciplinary Team and Independent Expert Panel joint fact finding: Summary of the experts' reports, [MDTIEP_FINALREPORT_ENG_January292017_000.pdf](https://cao-ombudsman.org/MDTIEP_FINALREPORT_ENG_January292017_000.pdf) (cao-ombudsman.org) 01.2017

Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын асуудал: сүүлийн үйл явц

Малчдын төлөөлөгчид 2012 онд гаргасан гомдолдоо тогтвортой ажилтай болоход мэргэшлийн сургалтад хамруулах, сургалтын нэмэлт тэтгэлэг, хичээлийн хэрэгслээр хангах, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн малчдад ерөнхий дэмжлэг үзүүлэх, мөн нөхөн олговрын багцыг хуваарилахад илүү ил тод байдлыг шаардаж байв. Мөн энэ гомдолдоо ОТ уурхай дахь дуу чимээ, тоос шороо зэргээс эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг нөхөн олговрыг тооцох аргачлалд заавал харгалзахыг шаарджээ.³³ 2017 оны MDT - Олон талт мэргэжлийн багаас гаргасан тайланд өртсөн малчдад тогтвортой амьжиргааг нь хангах хангалттай дэмжлэг үзүүлж чадаагүй тул 2004, 2011 онуудын нөхөн олговрын ажиллагаа нь ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 5-д нийцээгүй болохыг хүлээн зөвшөөржээ.³⁴

Эдгээр дүгнэлтүүдийн мөрөөр 2017 оны Өргөдөл гомдлыг шийдвэрлэх хэлэлцээрт нөхөн төлбөрийн хувь хүний болон нийт дундын багцуудыг оруулж нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны шууд нөлөөлөл мөн нутгийн нийгэмлэгт зайлшгүй учрах ирээдүйн нийгмийн ба хүрээлэн орчны нөлөөллийг харгалзахыг хичээсэн байна. Хувь хүнийнөхөн төлбөрийн үүргүүдийг дуусгах төлөвтэй байна: 2020 оны 6-р сарын байдлаар батлагдсан 157 нэхэмжлэлийн 148-ыг хуваарилж, ОТ ХХК нь 2017 оноос хойш 1.2 сая ам.долларын нөхөн олговрыг малчдад нэмж олгожээ.³⁵ Ахиулсан Мониторингийн хөтөлбөр, Тогтвортой амьжиргаа 10 хэсэгт хөтөлбөр зэрэг ихэнх амлалтууд хөдөлсөн төдий боловч малчдын сонирхлыг ихээхэн татах нийт дундын нөхөн олговрын хөтөлбөрийн хэсэг нь төлөвлөлтийн үе шатнаас хэтрээгүй байна. Эдгээрт малчдын зах зээл, мал нядалгааны шугам байгуулах зэрэг орно, ач холбогдол нь тухайн бүс нутагт уурхайн эрчимжсэн үйл ажиллагаанаас мал аж ахуйд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, малчдын амьжиргааг дэмжих чадавхийг нь дээшлүүлэхэд оршино. Эдгээр төслүүдийг хэрхэн удирдах тал дээр маргаан үүсч амлалтууд хойшлогдсоор байна.

Мөн түүнчлэн, Хариуцлагын зөвлөл нь 2017 оны гэрээний хэрэгжилт удаашралтай байгааг тэмдэглэж, уурхайн төслийн талаархи ил тод байдал, оролцоот ажиллагааг хангаагүй ба хүний нөөцийн дутагдал зэрэг хүндрэлүүд үүргийн биелэлтийн удаашралын шалтгаан гэж ажиглажээ. Жишээлбэл, ГТЗ-д дэх малчдын бүрэлдэхүүн(МБ)-ийг малаа маллаж буй малчдаас сонговол цаг зав гаргахад хүндрэлтэй, мөн идэвхгүй малчдаас бүрдүүлвэл мал маллаж буй хэсгийнхээ бодит

³³ OT Watch to Megan Taylor, Vice-President, Compliance Advisor Ombudsman [OyuTolgoiCAOComplaint_Oct122012_Redacted.pdf](https://www.cao-ombudsman.org/OyuTolgoiCAOComplaint_Oct122012_Redacted.pdf) (cao-ombudsman.org)

³⁴ JSL Consulting Ltd., MultiDisciplinary Team and Independent Expert Panel joint fact finding: Summary of the experts' reports, [MDTIEP_FINALREPORT_ENG_January292017_000.pdf](https://www.cao-ombudsman.org/MDTIEP_FINALREPORT_ENG_January292017_000.pdf) (cao-ombudsman.org) 16.

³⁵ Accountability Counsel, Commitment: Pasture, [From Paper to Progress Commitments](https://www.tpcprogress.com/) (tpcprogress.com): Tracking agreements between nomadic herders and Mongolia's largest copper mine, 05.02.2021-нд тавьсан.

хэрэгцээг мэдэхгүй гэх болгоомжлол малчдын дунд байгаа аж.³⁶ Хариуцлагын зөвлөл нь малчдын гомдолд дурдсан сөрөг нөлөөллийг арилгах амлалтууд бүрэн хэрэгжих эсэх нь туйлын тодорхой бус байна гэж дүгнэжээ.

Усны нөөцөд нөлөөлөх нөлөөллийн талаархи гомдол: сүүлийн үеийн явц

2013 оны 2-р сард долоон малчин "Говийн хөрс" ба OT Watch-ын дэмжлэгтэйгээр уурхайн төслийн хүрээнд Ундай голын голдиролыг өөрчилснөөр нутгийн усны нөөцийг багасгахад хүргэж болзошгүй, улмаар бэлчээрийн өвсний гарц чанар муудах асуудлаар CAO-д хоёр дахь гомдлоо хүргүүлсэн байна. Нэхэмжлэгчид голдирол өөрчлөх ажлыг дуусгаж, нөлөөлөлд өртсөн малчдад зохих нөхөн олговрыг олгохыг шаардсан болно.³⁷ Үүнийг Хараат бус шинжээчдийн бүлэг IEP дэмжиж, усны нөөцийн талаар хийсэн бие даасан судалгаандаа Ундай, Халив-Дугат голын голдрилыг өөрчлөх зэрэг үйл ажиллагаа нь уламжлалт мал аж ахуйд эргэлт буцалтгүй нөлөөлөх нь гарцаагүйг тэмдэглэж, чамбай үнэлгээ хийж байхын чухалыг тэмдэглэжээ. Олон талт мэргэжлийн багийн тайланд 'хөрсний уст давхаргын системчилсэн хяналт, загварчлал үгүй [ба] OT-ийн үйл ажиллагаа малчдын амьдралд нөлөөлөх эсэхийг системчилсэн байдлаар үнэлдэггүй нь OT-н бүс нутаг дахь үйл ажиллагаа нь усны нөөцөд хир их хохирол учирсныг тогтоох [боломжгүйд хүргэж байна]³⁸ гэжээ.

Зохистой суурь үнэлгээ хийгдээгүйгээс гадна олон тооны худаг барихад OT хайхрамжгүй хандсанаас ус шүүрэх, усны нөөц татрахад нөлөөлсөн байж болзошгүй гэж тайланд дурджээ.³⁹ 37 цооног барихдаа зөвхөн хайрга (бетоны оронд) ашиглан, Гүний хоолой ба гүехэн уст давхаргын хооронд нь ялгалгүй, гүехэн уст давхаргыг ширгээсэн гэж мэдээлжээ.⁴⁰ Эдгээрээс зургаан худгийг бетоноор битүүмжилж, хоёрыг

³⁶ Accountability Counsel, [from-paper-to-progress.pdf \(accountabilitycounsel.org\)](https://www.accountabilitycounsel.org/files/2019/02/Tracking-agreements-between-nomadic-herders-and-Mongolia's-largest-copper-mine-02.2019.pdf): 8 Tracking agreements between nomadic herders and Mongolia's largest copper mine, 02.2019.

³⁷ Compliance Advisor Ombudsman, CAO Dispute Resolution Conclusion Report - Oyu Tolgoi 01 & 02/Southern Gobi. [CAOMongolia Conclusion Rpt 2020-05-ENG.pdf \(cao-ombudsman.org\)](https://www.cao-ombudsman.org/files/2020/05/CAOMongolia-Conclusion-Rpt-2020-05-ENG.pdf)

³⁸ Accountability Counsel, Executive Summary (IEP findings) [1.30.15-IEP-Findings-Exec-Summary.pdf \(accountabilitycounsel.org\)](https://www.accountabilitycounsel.org/files/2015/01/1.30.15-IEP-Findings-Exec-Summary.pdf), 30.01. 2015.

³⁹ JSL Consulting Ltd., MultiDisciplinary Team and Independent Expert Panel joint fact finding: Summary of the experts' reports, 9. [MDTIEP_FINALREPORT_ENG_January292017_000.pdf \(cao-ombudsman.org\)](https://www.cao-ombudsman.org/files/2017/01/MDTIEP_FINALREPORT_ENG_January292017_000.pdf)

⁴⁰ Paul Robinson, 'Ус ба уул уурхай - Уурхайн зураг төсөл, төлөвлөлтийн шатнаас сөрөг нөлөөллөөс зайлсхийх, ашиглалтын хэрэглээг байгаль орчны эмзэг байдалтай тэнцвэржүүлэх', Нөлөөллийг бууруулах шатлал: том болон жижиг уул уурхайн байгаль орчин дахь нөлөөллийг бууруулах, Бага хурал, [2015-05-27 Water and Mining - Impact Avoidance - Mongolia.ppt \(sric.org\)](https://www.sric.org/files/2015/05/27-Water-and-Mining-Impact-Avoidance-Mongolia.ppt), Ulaanbaatar, Mongolia.

малчдын хүсэлтээр үүссэн цөөрмийн хамт үлдээжээ. Харин үлдсэн 29 худагт үнэлгээ хийгдээгүй тул хөрсний усны давхаргад учирсан хохирлын хэмжээг дүгнээгүй гэсэн үг. Эцэст нь голын голдиरोлыг өөрчилсөн нь бэлчээрийн нөөцийг эргэлт буцалтгүй алдах, мөн газар нутгийг дахин хуваарилахад хүргэсэн бөгөөд энэ нь тухайн бүс нутагт уламжлалт мал аж ахуй эрхлэхэд үлэмж их нөлөө үзүүлсэн ба цаашид ч үзүүлсээр байх болно.

2017 оны 5-р сарын Өргөдөл гомдлыг шийдвэрлэх гэрээгээр Ундай голын голдиरोлыг өөрчилсний нөлөөг бууруулах төрөл төрлийн арга хэмжээ авахаар, тухайлбал бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулахаар тохиролцсон юм.⁴¹ Уурхайн компани нь нутгийн усны нөөцийн гидрологийн судалгаа хийж, тэрхүү судалгаанд үндэслэн 12 малчны худаг шинээр барьж, мөн байгаа худгуудын үйлчилгээг хариуцах үүрэг хүлээжээ. Амлагдсан нарны хүчээр ажиллах худгуудыг 2020 оны 6-р сард барьж дуусгасан боловч, тэдгээрийг ОТ ХХК-иас гидрологийн судалгаа хийлгүйгээр барьсан байна.

Цаашилбал, ОТ-ийн барьж байгуулсан худгийн тоо нь ашиглагдаагүй бэлчээрт шилжих хөдөлгөөнийг дэмжих зорилгоор Олон талт мэргэжлийн багаас анх зөвлөсөн 75 цооногоос үлэмж цөөн байна. Хариуцлагын зөвлөл нь ОТ-н талаархи 2019 оны тайлан илтгэлдээ 2018 оны 6-р сард энэ нутагт ган гамшиг учирч, малчин өрхүүдэд мал сүргээ тэжээн тэтгэхэд мэдэгдэхүйц хүндээр туссан ба зарим нь усгүй, бэлчээргүйн улмаас малаа борлуулж байсан тухай дурдсан байдаг.⁴² Хариуцлагын зөвлөлөөс дэмжлэг хуваарилахдаа эдгээр эмзэг өрхүүдийг анхааралдаа авахыг ГТЗ-д зөвлөсөн боловч ГТЗ нь ямар нэгэн арга хэмжээ авсан эсэх нь тодорхойгүй байна.⁴³

Гомдлын шийдвэрлэлтэд тусгагдаагүй онцгой нөлөөллүүд

Хараат бус шинжээчдийн бүлэг (IEP) болон Олон талт мэргэжлийн баг (MDT)-ийн тайлан илтгэлүүдэд сэрэмжлэн дурдсан асуудлууд гомдол шийдвэрлэх ажиллагаанд тусгагдаагүй байдаг.

Нутгийн иргэд, мал аж ахуйд сөргөөр нөлөөлж малчдын санааг ихээхэн зовоосон нэг асуудал нь тухайн бүс нутагт шороон зам, элсний карьераас гарч буй тоосжилт

⁴¹ Accountability Council, Commitments: Water, [From Paper to Progress Commitments \(tpcprogress.com\)](https://www.tpcprogress.com): tracking agreements between nomadic herders and Mongolia's largest copper mine, 05.02.2021-нд тавьсан.

⁴² Accountability Counsel, [from-paper-to-progress.pdf \(accountabilitycounsel.org\)](https://www.accountabilitycounsel.org): Tracking agreements between nomadic herders and Mongolia's largest copper mine.

⁴³ Ил тод байдлын тухайд дурдвал зохих өөр нэг асуудал бол ОТ-н үүрэг амлалтын нэг Бие даасан техникийн хяналтын зөвлөлөөр хаягдал агуулах байгууламжиндаа үнэлгээ хийлгүүлэх байсан боловч илтгэлийн нь бүрэн бус хувилбар буюу боловсронгуй болгох зөвлөмж бүхий хавсралтгүйгээр нийтэлсэн асуудал юм. Үүний үр дүнд энэхүү амлалт эхлэл төдий шатандаа байсаар.

байдаг.⁴⁴ Олон талт мэргэжлийн баг (MDT) нь тоосжилт 2010 онд дээд цэгтээ хүрснийг тогтоож, "хэт их тоосжилт"-ын хариуцлагыг ОТ уурхай дангаараа үүрнэ гэж тодотгож чадаагүйгээс энэ асуудлыг цаашид хөөцөлдөөгүй ба энэхүү нөлөөллийн нөхөн төлбөрийг ч тогтоогоогүй болно. Энэхүү асуудлыг шийдвэрлэхээр ОТ-оос авсан арга хэмжээ нь ОТ-Ханбогд хоорондын 35 км замыг хатуу хучилттай болгосон (2019 онд баригдаж дууссан)⁴⁵ ба агаарын бохирдлыг хэмжих хяналтын төхөөрөмж суурьлуулсан ажил болно.

Төслийн 2012 оны БОННУ нь төслийн 2 дахь үе шатны өргөтгөл, хүлээгдэж буй нэмэгдэл нөлөөллийг тооцоогүй гэж олон удаа шүүмжлэгдэж байв.⁴⁶ Тодруулбал, Олон талт мэргэжлийн баг (MDT)-аас "Далд уурхайн төсөл, эрчим хүчний гэрээ, ажиллах хүчний байр сууцын төлөвлөгөөг өөрчлөх ... [эсвэл] 2012 оны БОННУ⁴⁷ нийтлэгдсэнээс хойш төсөлд орсон аливаа томоохон өөрчлөлтөд" ОУСК-ийн стандартад нийцсэн БОННУ гаргаж байхыг зөвлөж байв. Жишээ нь, ийм нэг БОННУ-ийг далд уурхайн хог хаягдлыг боловсруулах зорилгоор Халив Дугат гол дээр барих хаягдал хадгалах нэмэлт байгууламжийн түрээсийн талбайн өргөтгөлд хийсэн байвал зохино.⁴⁸ Ерөнхийд нь тэмдэглэхэд төслийн 2 дахь үе шатны хураангуй нөлөөллийн талаар тодорхой ойлголт огт алга байна.

⁴⁴ Accountability Counsel, IEP findings, 30 January 2015, p. 58. The full report is confidential. Please see an overview: [1.30.15-IEP-Findings-Exec-Summary.pdf \(accountabilitycounsel.org\)](https://www.accountabilitycounsel.org/1.30.15-IEP-Findings-Exec-Summary.pdf)

⁴⁵ Oyu Tolgoi, [Oyu Tolgoi funded 35.1 km road opens in Khanbogd \(ot.mn\)](https://www.ot.mn/oyu-tolgoi-funded-35-1-km-road-opens-in-khanbogd), has been inaugurated, 19 February 2019.

⁴⁶ Paul Robinson, Oyu Tolgoi Phase 2: Plans, Issues and Risks, CEE Bankwatch Network, 10 January 2016. <https://bankwatch.org/sites/default/files/OyuTolgoi-Phase2.pdf>

⁴⁷ Accountability Counsel, [1.30.15-IEP-Findings-Exec-Summary.pdf \(accountabilitycounsel.org\)](https://www.accountabilitycounsel.org/1.30.15-IEP-Findings-Exec-Summary.pdf), p. 16. The full report is confidential. Please see an overview: Executive Summary (IEP findings)

⁴⁸ 2017 онд имэйлээр ирүүлсэн товч танилцуулгадаа Southwest Research and Information Center-Баруун өмнөд эрдэм шинжилгээ, мэдээллийн төвийн Пол Робинсон нь ОТ-н "Уурхайн усны алдагдлын анхдагч эх үүсвэр болох хаягдал хадгалах байгууламж (ХХБ) нь олон хэмжигдэхүүнээр хангалтгүй ажиллаж байна" гэжээ. Үүнд хүлээгдэж буй хэмжээнээс хатуу бодисын агууламж багатайгаас үүдэн төлөвлөснөөс 14 хувиар бага усыг дахин боловсруулж, улмаар төсөлд шаардагдах усны хэмжээг эрс нэмэгдүүлж байж. Ийнхүү үр ашиггүй ажиллагаа нь ХХБ-ийн хүчин чадлыг төлөвлөснөөс 18 хувиар түргэн барагдуулж байна гэсэн үг ба уурхайн олборлолтыг нэмэгдүүлэх болон ашиглалтын бүх хугацаанд тохируулан ХХБ-ийн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой зураг төслийн асуудал үүсгэж байна" гэж тэмдэглэжээ. Мөн шинээр боловсруулах БОННУ-нд "оршин тогтноход шаардагдах 2 тэрбум гаруй долларын санхүүжилтийн хүрээнд газар доорхи тогтвортой байдлын хангах арга хэмжээг тусгаж, мөн Олон талт мэргэжлийн баг (MDT) ба Хараат бус шинжээчдийн бүлэг (IEP)-ийн тайланд дурдсан суурь түвшний хэрэгцээг шийдвэрлэх боломжийн" талаар дурдах шаардлага байгааг тэрээр тэмдэглэв.

Нүүрс шатаах цахилгаан станцын төсөл

ОТ нь 2020 оны 9-р сарын 3-нд Өмнөд бүсийн цахилгаан сүлжээнээс цахилгаан хэсэгчлэн нийлүүлэх гэрээ байгуулсан⁴⁹ боловч одоогийн байдлаар уурхайн эрчим хүчийг голчлон Хятадаас импортолж байна. Төслийн хоёр дахь үе шатанд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах боломжийн талаар яриа өрнөх явцад 2019 оны 6-р сард ОТ хувьцаа эзэмшигчид нь Тавантолгойд 300 мегаваттын хүчин чадалтай нүүрсээр ажиллах цахилгаан станцыг МУ-ын ЗГ-аар санхүүжүүлэн барих тохиролцоонд хүрсэн байдаг. Цахилгаан станцыг 2025 онд ашиглалтад оруулах ба 924 сая ам долларын өртөгтэй байхаар төлөвлөжээ. 2021 оны 3-р сар гэхэд оролцогч талууд цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээг эцэслэн байгуулснаар 2021 оны 7-р сараас барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байгаа байна.^{50 51} ОТ-ийн талаархи Хараат бус байгаль орчин, нийгмийн зөвлөх (Independent Environmental and Social Consultant (IESC))-ийн 2020 оны 5-р сарын тайланд дурдснаар ОТ нь нүүрсээр ажиллах цахилгаан станцын төслийн БОННУ-г 2019 оны 12-р сард хүргүүлсэн ба гол зээлдүүлэгчдийг төлөөлж IESC хянасан байна.⁵² Гэвч энэхүү аудитын ололтыг болон БОННУ-ний эх баримт бичгийг нийтэд мэдээлэх хүртээмж боломжгүй бололтой.

⁴⁹ Oyu Tolgoi, [Mongolia starts to partially supply power to the Oyu Tolgoi mine](#), 3 September 2020.

⁵⁰ Rio Tinto, [Agreement reached on a preferred long-term power supply for Oyu Tolgoi \(riotinto.com\)](#), 29 June 2020.

⁵¹ [Mongolia: Rio Tinto Unveils Plan For Coal-Fired Power Plant At Oyu Tolgoi | IEA Clean Coal Centre \(iea-coal.org\)](#) , 20 February 2020

⁵² RINA Consulting S.p.A, Oyu Tolgoi Mine Project: IESC Report - Desktop Audit, 7, May 2020. [IESC Report - Desktop Audit - May 2020 \(ot.mn\)](#)

Энэхүү илтгэлийг Европын Холбооны санхүүгийн туслалцаатай нийтлэв. Тайлангийн агуулгыг зөвхөн CEE Bankwatch Network хариуцна. Агуулга нь ямар нэгэн байдлаар Европын холбооны байр суурийг илэрхийлж байна гэж үзэж болохгүй.